

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар А/188

Улаанбаатар хот

ЗАРДЛЫН НОРМАТИВ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж норматив"-ыг нэгдүгээр, "Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хувцас, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэлийн зардлын дундаж норматив, эдэлгээний хугацаа"-г хоёрдугаар, "Төрөлжсөн асрамжийн газарт зайлшгүй байх эмийн жагсаалт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Төрөлжсөн асрамжийн газарт асруулж байгаад нас барсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон 0-18 хүртэлх насны хүүхдийн оршуулгын зардлын хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс тогтоосон хэмжээгээр тооцож холбогдох нийгмийн даатгалын сан, нийгмийн халамжийн сан, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлаас тус тус олгохоор тогтоосугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 247/А/163, 2016 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 52/А/20 дугаар хамтарсан тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД А.АРИУНЗАЯА